



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2376, 7032 2325,
Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn
Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2025. 01. 10 № 1/36

танай _____-ны № _____-Т

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНД

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн салбар хорооноос 2024 онд хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.



О.ПҮРЭВДОРЖ

6225 15 0030

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАГСДЫН
ХҮЙСИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫН 2024 ОНЫ МЭДЭЭ**

МАЯГТ-1а

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Улс төрийн нийт албан тушаалтан		Үүнээс удирдах АТ				Улс төрийн гүйцэтгэх зөвлөх/ туслах/бусад/ албан тушаалтан	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	Засаг дарга		Засаг дарга орлогч		эр	эм
							эр	эм	эр	эм		
1.	Өвөрхангай аймгийн ЗДТГазар	84	35	49	3		1		1		1	
2.	Арвайхээр сумын ЗДТГ	79	25	54	7	7	7	7		1		
3.	Баруунбаян-Улаан сумын ЗДТГ	18	11	7	6		6		1			
4.	Бат-Өлзий сумын ЗДТГ	24	10	14	7	1	6	1	1			
5.	Баянгол сумын ЗДТГ	18	9	9	5	2	5	1		1		
6.	Баян-Өндөр сумын ЗДТГ	21	11	10	7		6		1			
7.	Богд сумын ЗДТГ	22	14	8	9		8		1			
8.	Бүрд сумын ЗДТГ	20	10	10	4	2	4	2		1		
9.	Гучин-Ус сумын ЗДТГ	18	7	11	5	1	4	1	1			
10.	Есөнзүйл сумын ЗДТГ	17	10	7	6		5		1			
11.	Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ	21	13	8	8		7		1			
12.	Нарийнтээл сумын ЗДТГ	21	13	8	6		5		1			
13.	Өлзийт сумын ЗДТГ	16	10	6	5		5					
14.	Сант сумын ЗДТГ	18	9	9	5	2	4	2	1			
15.	Тарагт сумын ЗДТГ	21	10	11	8		7		1			
16.	Төгрөг сумын ЗДТГ	20	7	13	5	2	6	1		1		
17.	Уянга сумын ЗДТГ	26	13	13	10		9		1			
18.	Хайрхандулаан сумын ЗДТГ	22	16	6	8		7		1			
19.	Хархорин сумын ЗДТГ	43	22	21	10		9		1			
20.	Хужирт сумын ЗДТГ	21	11	10	5	3	4	3	1			
	Нийт дүн	550	266	284	129	20	115	18	15	4	1	

МАЯГТ-16

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Төрийн захиргааны АХ		Үүнээс удирдах АТ				Төрийн захиргааны гүйцэтгэх		Төрийн захиргааны туслах	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	ЗДТГ-ын дарга		Хэлтэс, албадын дарга		эр	эм	эр	эм
							эр	эм	эр	эм				
1.	Өвөрхангай аймгийн ЗДТГазар	84	35	49	12	28	1		3	4	9	24		
2.	Арвайхээр сумын ЗДТГ	79	25	54	5	22		1			5	22		
3.	Баруунбаян-Улаан сумын ЗДТГ	18	11	7	3	4		1			3	3		
4.	Бат-Өлзий сумын ЗДТГ	24	10	14	1	8	1			1		7		
5.	Баянгол сумын ЗДТГ	18	9	9	3	3	1				3	3		
6.	Баян-Өндөр сумын ЗДТГ	21	11	10	2	7	1			1	2	7		
7.	Богд сумын ЗДТГ	22	14	8	2	5	1				2	5		
8.	Бүрд сумын ЗДТГ	20	10	10	4	3		1			4	2		
9.	Гучин-Ус сумын ЗДТГ	18	7	11		7		1				6		
10.	Есөнзүйл сумын ЗДТГ	17	10	7	3	2	1				2	2		
11.	Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ	21	13	8	3	6	1				2	6		
12.	Нарийнтээл сумын ЗДТГ	21	13	8	3	5		1			3	4		
13.	Өлзийт сумын ЗДТГ	16	10	6	4	3	1				3	3		
14.	Сант сумын ЗДТГ	18	9	9	3	4	1			1	2	3		
15.	Тарагт сумын ЗДТГ	21	10	11		8		1				6		
16.	Төгрөг сумын ЗДТГ	20	7	13		7		1				7		
17.	Уянга сумын ЗДТГ	26	13	13	2	9		1			2	8		
18.	Хайрхандулаан сумын ЗДТГ	22	16	6	10	4	1				5	3		
19.	Хархорин сумын ЗДТГ	43	22	21	4	9		1			4	8		
20.	Хужирт сумын ЗДТГ	21	11	10	2	6		1		1	2	5		
	Нийт дүн	550	266	284	66	150	10	10	3	8	53	134		

МАЯГТ-1в

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Төрийн үйлчилгээний АХ		Үүнээс удирдах АТ		Төрийн үйлчилгээний гүйцэтгэх		Төрийн үйлчилгээний туслах	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	Хэлтэс, албадын дарга		эр	эм	эр	эм
							эр	эм				
1.	Өвөрхангай аймгийн ЗДТГазар	84	35	49	16	15	1		5	7	10	8
2.	Арвайхээр сумын ЗДТГ	79	25	54	13	24			13	24		
3.	Баруунбаян-Улаан сумын ЗДТГ	18	11	7	2	3			2	3		
4.	Бат-Өлзий сумын ЗДТГ	24	10	14	2	5			1	4	1	1
5.	Баянгол сумын ЗДТГ	18	9	9	1	4				3	1	1
6.	Баян-Өндөр сумын ЗДТГ	21	11	10	2	3				2	2	1
7.	Богд сумын ЗДТГ	22	14	8	2	3			1	2	1	1
8.	Бүрд сумын ЗДТГ	20	10	10						1	1	1
9.	Гучин-Ус сумын ЗДТГ	18	7	11	3	3			1	2	2	1
10.	Есөнзүйл сумын ЗДТГ	17	10	7	1	4				3	1	1
11.	Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ	21	13	8	3	2			2	1	1	1
12.	Нарийнтээл сумын ЗДТГ	21	13	8	4	3			3	2	1	1
13.	Өлзийт сумын ЗДТГ	16	10	6	2	2			1	2	1	
14.	Сант сумын ЗДТГ	18	9	9	1	3				2	1	1
15.	Тарагт сумын ЗДТГ	21	10	11	1	4				3	2	1
16.	Төгрөг сумын ЗДТГ	20	7	13	1	3			1	3		
17.	Уянга сумын ЗДТГ	26	13	13	1	4			1	4		
18.	Хайрхандулаан сумын ЗДТГ	22	16	6	2	2			1	2	1	
19.	Хархорин сумын ЗДТГ	43	22	21	8	12				8	1	2
20.	Хужирт сумын ЗДТГ	21	11	10	1	4			1	4		
	Нийт дүн	550	266	284	66	103	1		33	82	27	21

МАЯГТ-1г

№	Нутгийн захиргааны байгууллага, харьяа сумдын ЗДТГ	Төрийн албан хаагчид /үндсэн/			Төрийн тусгай АХ		Үүнээс удирдах АТ		Төрийн тусгай гүйцэтгэх		Төрийн тусгай туслах	
		Нийт	эрэгтэй	эмэгтэй	эр	эм	Хэлтэс, албадын дарга		эр	эм	эр	эм
							эр	эм				
1.	Өвөрхангай аймгийн ЗДТГазар	84	35	49	4		1		3			
	Нийт дүн				4		1		3			

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУРСАН:

ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.ХОРОЛСҮРЭН

ЖЕНДЭРИЙН ДЭД САЛБАР ХОРОО БАЙГУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

№	СУМЫН НЭР	ШИЙДВЭРИЙН ОГНОО	ШИЙДВЭРИЙН ДУГААР	ТАЙЛБАР
1	Арвайхээр	2024 оны 02 дугаар сарын 05	A/33	2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн A/33 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
2	Уянга	2024 оны 04 дүгээр сарын 03	A/61	2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн A/61 дүгээр захирамжаар жендэрийн дэд хороог шинэчлэн байгуулсан.
3	Гучин-Ус	2024 оны 02 дугаар сарын 12	A/27	2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн A/27 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
4	Богд	2024 оны 05 дугаар сарын 06	A/52	2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн A/52 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
5	Бат-Өлзий	2024 оны 02 дугаар сарын 02	A/31	2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн A/31 дүгээр захирамжаар жендэрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
6	Баян-Өндөр	2024 оны 09 дүгээр сарын 12	A/204	2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн A/204 дүгээр захирамжаар жендэрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
7	Хархорин	2024 оны 01 дүгээр сарын 30	A/07	2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн A/07 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
8	Хужирт	2024 оны 03 дугаар сарын 13	A/47	2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн A/47 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
9	Хайрхандулаан	2024 оны 05 дугаар сарын 09	A/39	2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн A/39 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
10	Баруунбаян-Улаан	2024 оны 04 дүгээр сарын 22	A/28	2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн A/28 дугаар захирамжаар жендэрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

11	Нарийнтээл	2024 оны 10 дугаар сарын 02	A/113	2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн A/113 дугаар захирамжаар жөндөрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
12	Төгсөг	2024 оны 06 дугаар сарын 05	A/69	2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн A/69 дүгээр захирамжаар жөндөрийн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

-- оОо --

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Салбар хорооны гишүүний овог нэр	Хүйс	Албан тушаал	“Жендэр ба бодлого төлөвлөлт” анхан шатны сургагч багшийн модулиар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх	Төрийн албаны удирдах албан тушаалтны жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх	Утасны дугаар	Цахим хаяг	Чиг үүрэг, хариуцаж буй үйл ажиллагааны хүрээ
1	Очирын Пүрэвдорж	эр	Аймгийн Засаг дарга	үгүй	үгүй	99991296		Салбар хорооны дарга
2	Мягмарсүрэнгийн Батзориг	эр	Аймгийн Засаг даргын орлогч	үгүй	үгүй	99115508		Салбар хорооны дэд дарга
3	Цэрэнтүндэвийн Ганболд	эр	Аймгийн ЗДТГ-ын дарга	үгүй	үгүй	99049825	ban6954@yahoo.com	Салбар хорооны гишүүн
4	Бямбадоржийн Сайнжаргал	эм	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	тийм	тийм	99067603	banaa_0606@yahoo.com	Салбар хорооны гишүүн
5	Цэрэннадмидын Идэрсайхан	эр	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	үгүй	үгүй	88002632		Салбар хорооны гишүүн
6	Адъяасүрэнгийн Отгонцэцэг	эм	Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга	үгүй	үгүй	99199576	otgoonzh@gmail.com otgontsetseg@ov.gov.mn	Салбар хорооны гишүүн
7	Тогоогийн Үржинпүрэв	эм	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга	үгүй	үгүй	99047900		Салбар хорооны гишүүн

8	Охинтогтохын Түмэнжаргал	эм	Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга	үгүй	үгүй	99008338	Tumenjargal_O@ nso.mn	Салбар хорооны гишүүн
9	Ганболдын Чимэддагва	эр	Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга	үгүй	үгүй	99104787		Салбар хорооны гишүүн
10	Батнасангийн Ганбаяр	эр	Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	үгүй	үгүй	99848000		Салбар хорооны гишүүн
11	Ганболдын Пүрэвдорж	эр	Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	үгүй	үгүй	99997184		Салбар хорооны гишүүн
12	Нэргүйн Цэвээндулам	эр	Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга	үгүй	үгүй	99055814		Салбар хорооны гишүүн
13	Пүрэвийн Пунсалмаа	эм	Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	үгүй	үгүй			Салбар хорооны гишүүн
14	Наранмандахын Туул	эм	Хүний эрхийн үндэсний комиссын Өвөрхангай аймаг дахь салбарын ажилтан	үгүй	үгүй	99028089		Салбар хорооны гишүүн

15	Чимэдцэрэнгийн Ганцэцэг	эм	Өвөрхангай аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын нэгдсэн холбооны зохицуулагч	үгүй	үгүй	99727022	Leos.Arvalneer@gmail.com	Салбар хорооны гишүүн
16	Аюурзанын Өнөдэлгэр	эм	"Best" бичиг хэргийн дэлгүүрийн менежер	үгүй	үгүй	88325051		Салбар хорооны гишүүн
17	О.Гансүх	эр	Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Өвөрхангай аймаг дахь салбарын тэргүүн	үгүй	үгүй	88098260	Gsukhee931@gmail.com	Салбар хорооны гишүүн
18	Эрдэнэ-Очирын Хоролсүрэн	эм	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Жендэрийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	үгүй	үгүй	99795886	khnkhortoc0127@gmail.com	Салбар хорооны нарийн бичгийн дарга

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ БИЕЛЭЛТ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРОО

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Биелэлт	Салбар хорооны өөрийн үнэлгээ	ХШҮХ-ийн үнэлгээ
				2023 он	2024 он			
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031 он)								
Стратеги төлөвлөгөөний батлагдсан огноо: 2022 оны 10 дугаар сарын 05.								
ЗОРИЛГО 1. Охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ.								
Зорилт 1.1. Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана.								
1.1.1	Жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хорт зуршлын хэрэглээг бууруулахад иргэдийн мэдлэг, хандлагыг сайжруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	-	-хэрэгжилтийн хувь		80-аас дээш	Иргэдэд архиан согтуурахаас сэргийлэх, давсны хэрэглээг бууруулах, сүрьеэ, гепатиттай тэмцэх, тамхигүй, авто машингүй өдөр болон орчны эрүүл мэнд, гар угаах өдрүүд, оюутан, сурагчдын эрүүл мэндийг дэмжих 2 сарын, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян зэрэг тэмдэглэлт өдрүүдээр үйл ажиллагаа тогтмол зохион байгуулж байна. Цэрэг, цагдаа, онцгой байдлын албан хаагчид, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэн, оюутан сурагчид, цэргийн насны залуучуудад зориулсан 46 удаагийн сургалт зохион байгуулж, 1659 хүнийг хамруулан, эрүүл ахуйн дадал хэвшил олгох 11 төрлийн 1600 гаруй санамж, брошур түгээсэн байна. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын болон бусад байгууллагуудын цахим хуудаст 300 төрлийн постер, санамж,	90.0	90.0

шторк, сурталчилгаа, зөвлөгөөг байршуулж, 200000 орчим хүн хандаж мэдээлэл авсан. Архидан согтуурахаас сэргийлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус 94 байгууллагад сургалт хийж, өөртөө туслах бүлгийн 20, архины хамааралтай 31 иргэнтэй бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж, хандлага, дадал хэвшлийг өөрчлөх алхамуудыг тайлбарлан таниулсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд сум, багийнхаа иргэдээс давсны хэрэглээний судалгаа авч, дүгнэхэд судалгаанд хамрагдсан иргэдийн 70 гаруй хувь нь хоногт 5 грамм хүртэлх давс хэрэглэж байгаа нь иргэдийн дунд давсны зохистой хэрэглээний зэрэг хандлага төлөвшиж байгааг харуулж байна. Сүрьеэ өвчнөөр өвдөх эрсдэл бүхий 10000 гаруй хүний судалгааг гаргаж, 4300 хүн буюу 43.0 хувийг үзлэг, шинжилгээнд хамруулан, 264 хүнийг илрүүлэн, эмчилгээ, хяналтад аваад байна.

Сумдын Насан туршийн боловсролын нэгжийн багш нарыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр цэргийн насны залуучуудад сургалт, нөлөөллийн ажил хийх сургагч багшаар бэлтгэж, 2024 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын үзлэгт хамрагдсан 4000 орчим залуучуудад сургалт хийж, мэдээлэл өглөө.

1.1.2	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетын үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх	-	- үйлчлүүлэгчдийн тоо	230	300	90.0	90.0
1.1.3	Эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн үлгэр жишээ эрэгтэйчүүдийн амьдралын туршлага, ололт амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх	800.0 мянга	- нэвтрүүлгийн тоо	-	2	90.0	90.0
Зорилт 1.2. Эрүүл идэвхтэй, жендэрийн ялгаварлалгүй амьдралын хэв маягийг боловсрол, соёл, спортоор төлөвшүүлнэ.							
1.2.1	Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх хөдөлгөөн өрнүүлэхэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн олон нийтийн байгууллагын оролцоог дэмжих.	-	-арга хэмжээний тоо	2	3	90.0	90.0
			-оролцогчдын тоо	12000	15000		
1.2.2	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын арга	-	-сургалтын тоо	37	45		

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эрэгтэйчүүдэд тусламж үйлчилгээ үзүүлэх өрөөг ажиллуулж, андрологи, урологийн үзлэгт 400 гаруй эрэгтэй хамрагдаж, 224 хүнийг хэвтүүлэн эмчилж, үйлчилгээ үзүүлсэн байна. 16 эрэгтэйд урологийн мэс засал хийж, эрүүлжүүлсэн байна.

Соёл, урлагийн газраас эерэг, зөв эр хүн, хариуцлагатай аав байх талаар залуучуудад чиглэсэн видео контент, постерийг бүтээж иргэд олон нийтэд түгээсэн байна. "Миний гэр бүл-миний аз жаргал" өдөрлөгийг жил бүр зохион байгуулж, залуу, дунд, ахмад 3 үеийн үлгэр жишээ гэр бүлийг алдаршуулан, сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээж хэвшээд байна. Энэхүү арга хэмжээнд 2024 онд Арвайхээр сумын 100 гаруй гэр бүлийн 230 орчим иргэд оролцлоо,

Аймаг, сумдын ахмадын болон эмэгтэйчүүдийн байгууллага, "Зөв цаг" бүжгийн клуб, фитнес клубуудтэй хамтран хүүхэд, залуучууд, ахмад настан, иргэдийн дунд идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, хэвшүүлэх нийтийн биеийн тамирын арга хэмжээг 600 гаруй удаа зохион байгуулж, 34323 эмэгтэй, 20551 эрэгтэй нийт 54874 иргэн хамрагдсан байна.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан "Та татгалз" арга

зүйг хөгжүүлж, сум, багт жигд хүртээмжтэй зохион байгуулах	-сургалтанд оролцогчдын тоо	600	650-750	хэмжээний хүрээнд сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр цахим хуудсаар 5 контент, 9 төрлийн мэдээ бэлтгэн байршуулж, яриа таниулга, сургалт сурталчилгаа 84, согтууруулах ундаа худалдан борлуулж, түүгээр үйлчилдэг 168 хуулийн этгээдэд уриалга гаргуулж, 21 лед дэлгэц, 6 ширхэг хулдаасан самбарыг гудамж талбайд байршуулсан. Мөн 285 аж ахуй нэгж байгууллагад 2 төрлийн 3500 ширхэг санамж сэрэмжлүүлгийг олшруулан тарааж, урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудаст байршуулсан контент, постер, мэдээллийг 42 группээр 8801 удаагийн түгээлт хийж, иргэд олон нийтэд хүргэсэн. Архи, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг, мансуурах, архинд донтох өвчтэй этгээдүүдийг хяналтад авч, архины албадан эмчилгээнд 2, сайн дурын эмчилгээнд 112 иргэнийг хамруулж, эмнэл зүйн болон сэтгэл зүйн эмчилгээ хийж, зан үйлд нөлөөлөх бүлгийн сургалтыг аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сэтгэц наркологийн тасагтай хамтран зохион байгуулсан.	90.0	90.0
Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг хорт зуршил, болзошгүй эрсдэлт зан үйл болон жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх	-арга хэмжээний тоо	-	32	Аймгийн Засаг даргын 2022 оны А/136, 2023 оны А/327 дугаар “Утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай” захирамжийн хүрээнд олон ажлыг хэрэгжүүлж байна. “Электрон		
	-хамрагдсан сурагчдын тоо	-	1800			

үйл ажиллагааг эцэг эх,
багш, сурагчид (охид,
хөвгүүд)-ын клуб,
бүлгээр дамжуулан
идэвхжүүлж дэмжих

тамхины хэрэглээ, түүний хор уршиг”
сэдэвт хэлэлцүүлгийг зохион
байгуулж, төр, төрийн бус
байгууллага, боловсрол, эрүүл мэнд,
хуулийн салбарын төлөөлөл,
Арвайхээр сумын ЕБ-ын зургаан
сургуулийн удирдлага, нийгмийн
ажилтан, сурагч, эцэг эх, асран
хамгаалагчид, Политехник
коллежийн нийгмийн ажилтан,
суралцагчид, хэвлэл мэдээллийн
байгууллагын төлөөлөл 100 гаруй
хүн оролцож, Арвайхээр суманд
хийгдсэн “Утаат болон электрон
тамхи, түүний дагалдах хэрэгслийг
худалдан борлуулах үйл
ажиллагаанд хяналт хийсэн тайлан”,
“Тамхины хэрэглээний өнөөгийн
байдал ба Электрон тамхины хор
уршиг”, “Арвайхээр сумын ЕБ-ын
сургуулиудын сурагчдын тамхины
хэрэглээний өнөөгийн байдал”
сэдвүүдээр мэдээлэл авч, санал
солилцлоо. Боловсрол, шинжлэх
ухааны газраас ерөнхий
боловсролын сургуулийн сурагчдын
нийгмийн ухааны хичээлээр тэгш эрх,
нийгмийн ялгарал, шударга ёс, эрхэм
чанар, үл ялгаварлан гадуурхах,
хүний эрхийн ойлголтуудыг заахдаа
жендерийн талаар ойлголт
мэдээллээр хангаж ярилцлага
хэлэлцүүлэг хийж байхыг түүх,
нийгмийн ухааны багш нарт чиглэл
болгож байна.

90.0

90.0

1.2.4	Боловсролын сургалтын байгууллагад ажиллаж буй сэтгэл зүйчийг жендэрийн чиглэлээр мэргэшүүлэх	-	-жендэрийн чиглэлээр мэргэшсэн сэтгэл зүйчийн тоо	-	6	Арвайхээр сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд, БШУГ-ын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний хамт "Жендэр ба хүний эрх" сургалтад хамрагдан жендэрийн талаар ойлголт, статистик, эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, мэдрэмж, ажлын байр бэлгийн дарамтгүй орчин, урьдчилан сэргийлэх арга зам зэрэг ойлголтуудын талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, сургуулийнхаа дунд, ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгууллаа.	70.0	70.0
-------	---	---	---	---	---	---	------	------

Зорилт 1.3. Гэр бүл дэх тэгш харилцаа, хамтын үүрэг хариуцлагыг дэмжинэ.

1.3.1	Эцэг эхийн үүрэг хариуцлага, ажил-гэр бүлийн үүргээ хослуулах, гэр бүлийн боловсрол, харилцааны талаарх мэдлэг, ойлголт олгох сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	-	-сургалт зохион байгуулсан сум, байгууллагын тоо	10 сум 44 байгууллага	19 сум 60 аж ахуйн нэгж байгууллага	Гэр бүлийн боловсрол олгох "Гэр бүл төлөвлөлт" модуль сургалтаар 111, "Гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг хөтлөх нь" сэдвээр 1500, "Гэр бүлийн харилцаа, ёс зүй" сэдвээр 2104, "Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил, төлөвшил" сэдвээр 1100, нийт 4815 иргэнийг сургалтад хамруулж, гэр бүлийн үнэт зүйл, харилцааны талаар мэдлэг мэдээлэл өгч, ажиллалаа. Шинээр гэр бүл болж, гэрлэлтээ батлуулж байгаа залуу хосуудад Гэр бүлийн үнэ цэн, Гэр бүл төлөвлөлт, Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол сэдвээр сургалт зохион байгуулж, Улсын бүртгэлийн хэлтэс, Гэрлэх ёслолын ордонтой хамтран гэрлэлтийн гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулан өгч байгаа нь залуу хосуудад гэр бүлээ эрхэмлэн	100	100
			- оролцогчдын тоо	3600 хүн	4000 хүн			

1.3.2	Эерэг, зөв эр хүн, хариуцлагатай аав байх талаар өсвөр үе, олон нийт, эрэгтэйчүүдэд чиглэсэн драм, видео контент, шторк зэрэг бүтээгдэхүүн гаргах	-	-гаргасан бүтээгдэхүүний тоо	-	1	дээдлэх, эхнэр, нөхрийн үүрэг, хариуцлагаа ухамсарлах, хариуцлагатай гэр бүлийг бий болгоход чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна.	70.0	50.0
-------	---	---	------------------------------	---	---	--	------	------

Зорилт 1.4. Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн амьдралын орчин, суурь нөхцөлийг сайжруулна.

1.4.1	Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдэд бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, хүчирхийлэлгүй харилцааны талаарх мэдээллийг тогтмол хүргэх		-сургалт мэдээллийн тоо	5	20	Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдэд зориулсан "Амьдралын зөв дадал бий болгох, эрүүл урт наслах зан үйлийг хэвшил болгох" зорилтот аяныг Баян-Өндөр, Богд, Хужирт сумын эрүүл мэндийн төвүүд зохион байгуулж, 3091 хүнийг "Өглөөний цайны ач тус", "Зөв хооллолт", "Электрон болон утаат тамхины хор уршиг", "Осол гэмтлээс сэргийлэх нь", "Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдахын ач холбогдол" зэрэг сургалт, үйл ажиллагаанд хамруулж, 5 төрлийн 10400 ширхэг брошур гарын авлагаар хангасан байна. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс дэлхийн тамхигүй өдрийн хүрээнд гаргасан цахим сурталчилгааны 13 төрлийн постер, мөн тамхины хор уршиг, тамхины шалтгаант нас баралтын тоон мэдээ, тамхинд зарцуулагдах мөнгөн дүн,	70.0	70.0
			-хамрагдсан малчдын тоо	220	1000			

цаг хугацааны тооцоолол бүхий 5 төрлийн богино видео шинээр бэлтгэн эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудаст байршуулснаар 17503 хүн хандаж, мэдээлэл авсан.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх 16 хоногийн аяны хүрээнд "Харилцаагаа эрхэмлэхүй" сургалтын хүрээнд "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" сэдвээр 500 гаруй сум, ерхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтэнд мэдээлэл хүргэсэн.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр Койка олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжин нь" төслийн хүрээнд Өлзийт, Бүрд, Хархорин сумын төрийн албан хаагчид, малчид нийт 263 залуучуудад "Жендэрийн тухай ойлголт, хэвшмэл ойлголт" сэдвээр сургалт зохион байгуулж, мэдээлэл өглөө. Сургалтаар нийгэмд тулгамдаж буй асуудлыг хөндөж хэрхэн эерэгээр даван туулах, жендэрийн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлсэн нь үр дүнтэй сургалт боллоо.

Залуу малчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж нэвтрүүлэх

-

-хөтөлбөр хамрагдсан залуу малчид

-

1
500

70.0

70.0

Зорилт 1.5. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

1.5.1	Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамтын хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар хүртээмж, цар хүрээг сайжруулах	-	- хүүхэд - эмэгтэйчүүд	36 17	Хүүхэд, эмэгтэйчүүдийн тоог бууруулах	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвд 2024 онд 11 эмэгтэй, 26 хүүхэд байрлан сэтгэл зүйн үйлчилгээ авснаас 6 эмэгтэй, 12 хүүхдэд холбогдох асуудал хуулийн дагуу шийдвэрлэгдэж, 5 эмэгтэй 14 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, 6 хүүхдийг хамаатан төрөл саданд нь хүлээлгэн өгсөн.	90.0	90.0
1.5.2	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах	-	-сургалт, нөлөөллийн ажлын тоо -оролцогчдын тоо	37 600	45 650-750	Эдгээр хүүхэд, эмэгтэйчүүдэд давхардсан тоогоор 80 гаруй удаа сэтгэл зүйн зөвлөгөө, 24 удаа сэтгэл зүйн оношилгоо хийж, 30 гаруй удаагийн эрх зүйн зөвлөгөө өгч, сургалт нөлөөллийн хөгжүүлэх хөтөлбөрт хамруулж байна. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газраас чиг үүргийн байгууллагуудтай хамтран "Харилцан хүндэтгэе", "Анхаарч хамгаалъя", "Нандин тойрог-3", "Явуулын үйлчилгээ" зэрэг аян, тусгай, хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, 1000 орчим иргэд, хүүхэд, залуучууд хамрагдсан байна.	90.0	90.0

ЗОРИЛГО 2. Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ.

Зорилт 2.1. Хөдөлмөрийн зах зээл дэх нас, хүйсийн ялгаварлалыг бууруулна.

2.1.1	Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулж, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	500.0 мянга	-дотоод журамдаа тусгасан байгууллагын тоо -сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо	- 120	10 250	"Ажлын байр бэлгийн дарамтгүй орчин" сарын аяны хүрээнд Арвайхээр, Хархорин, Баянгол, Сант, Баян-Өндөр, Есөнзүйл, Бүрд сумын төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж, 400 орчим хүн хамрагдлаа. Ажлын байрны бэлгийн дарамт, түүний хор уршиг, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга зам, өртсөн тохиолдолд гомдол шийдвэрлүүлэх механизмын талаар оролцогчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан 16 хоногийн аянд нэгдэж, жендэрийн хэвшмэл, ташаа ойлголтоос татгалзах агуулга бүхий нөлөөллийн үйл ажиллагааг эрчимтэй давалгаалж, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцлоо. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, эдгээр 12 байгууллагад сургалт, нөлөөллийн ажлыг танхимаар зохион байгуулж, 180 гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан байна. Мөн цахим орчинд байршуулсан нөлөөллийн үйл ажиллагаа 15000 орчим хүнд хүрсэн байна.	90.0	90.0
2.1.2	Хувийн хэвшлийн байгууллагын жендэрийн төлөвлөлтийг сайжуулахад анхаарч, жендэрийн сургалтын модуль боловсруулж нэвтрүүлэх	300.0 мянга	-сургалтын модуль - жендэрийн талаар сургалт авсан хувийн хэвшлийн байгууллага	-	1 8	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, эдгээр 12 байгууллагад сургалт, нөлөөллийн ажлыг танхимаар зохион байгуулж, 180 гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан байна. Мөн цахим орчинд байршуулсан нөлөөллийн үйл ажиллагаа 15000 орчим хүнд хүрсэн байна.	100	100
2.1.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох		-шинээр ажилд орсон ХБ-тэй иргэдийн тоо (эр, эм)	-	10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 35 иргэнийг хамруулсны 12 буюу 34.2 хувь эмэгтэйчүүд байна. Тайлант онд төрийн байгууллагад 3, хувийн	100	100

Зорилт 2.2. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг жендэрийн агуулгаар бэхжүүлж, ажил, ар гэр, амьдралын тэнцвэрийг дэмжинэ.

<p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын жендэрийн агуулга, үр нөлөөг сурталчлан дэмжих</p>	-	<p>- байгууллагын тоо - сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо</p>	-	<p>15 350</p>	<p>хэвшлийн байгууллагад 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр ажилд зуучлагдсан байна.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар танхимын сургалтыг 18 удаа зохион байгуулж 84 байгууллагын 561 ажилтан, 39 иргэнийг хамруулсан. Тодруулбал АЗЗА-ТӨХК-ий 34, "Баянтээг" ХК-ний 26, Политехник коллежийн 58, Татварын хэлтсийн 17, "Арвайхээр Тохижилт үйлчилгээ" ОНӨАТҮГ-ын 36, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 14, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 20, Цагдаагийн газрын 43, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 20, "Эрдэнэт бүлган цахилгаан түгээх станц" ТӨХК-ний 42 албан хаагч тус тус хамрагдсан. Мөн Сант сумын 6 байгууллагын 25, Баянгол сумын 9 байгууллагын 14, Өлзийт сумын 7 байгууллагын 16, Есөнзүйл сумын 5 байгууллагын 12, Бүрд сумын 8 байгууллагын 14 нийт 5 сумын 35 аж ахуй, нэгж байгууллагын 81 ажилтан, албан хаагч сургалтад хамрагдаж мэдээлэл авлаа. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Хужирт, Хархорин суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Хужирт суманд 22 байгууллагын 71, Хархорин суманд 17 байгууллагын 96 ажилтан, Цагдаагийн газрын түр саатуулах байранд баривчлагдсан, согтуугаар тээврийн хэрэгсэл</p>	100	100
---	---	--	---	-------------------	--	-----	-----

						жолоодсон 39 иргэнийг тус тус хамруулан Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчилж мэдээлэл хийлээ.			
						Хүүхэд гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр 451 иргэн ганцаарчилсан, 54 иргэн бүлгийн зөвлөгөө авч үйлчлүүлснээс 36 гэр бүлд хосын зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн сэтгэл зүйн зөвлөгөө авсан байна. Нийт 575 иргэн сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө авсан байна.			
2.2.2	Төрийн үйлчилгээний байгууллагад харилцааны соёл, сэтгэлзүйн туслалцааг жендэрийн мэдрэмжтэй нэвтрүүлэх	- байгууллагын тоо - сэтгэл зүйн үйлчилгээ авсан албан хаагчдын тоо	-	10 100			90.0	90.0	
Зорилт 2.3. Эдийн засгийн нөөц баялгийн хүртээмж, эрх мэдлийн хуваарилалтад жендэрийн шударга байдлыг хангана.									
2.3.1	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүйсээр ангилсан статистик мэдээллийг холбогдох бодлого, хэрэгжилтэд ашиглах	-хэрэгжилтийн хувь	-	60-аас дээш хувь		2024 оны жилийн эцсийн байдлаар нийт хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 67.0 хувьтай байсныг хүйсийн байдлаар авч үзвэл эрэгтэй 74.7, эмэгтэй 60.2 хувь байна.	70.0	50.0	
2.3.2	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	-сургалтанд хамрагдсан төлөөлөгчийн тоо	-	30-аас дээш		"Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" сургалтад аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нар оролцож, мэдээлэл авлаа.	70.0	50.0	
Зорилт 2.4. Цар тахлын сөрөг нөлөөг даван туулах бодлого, үйл ажиллагааг жендэрийн агуулгаар хэрэгжүүлнэ.									
2.4.1	Ковид-19 цар тахлыг даван туулах, түүний нөлөөнөөс богино хугацаанд ангижрахад чиглэсэн тусгайлсан төлөвлөгөөг жендэрийн мэдрэмжтэй гаргаж, хэрэгжүүлэх	-төлөвлөгөө -хэрэгжилтийн хувь	2 80 хувь	2 90 хувь		Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн тэгш бус байдал 3 хүрээнд илэрдэг. Үүнд: Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн байдал, тэдэнд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, салбарын хүний нөөцийн хүйсийн харьцаа багтдаг. Иймээс бид Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх	90.0	90.0	

Цар тахлын үед болон дараа хөдөлмөрийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалт гарахаас сэргийлэх,

- зөвлөмж
-хэрэгжүүлсэн
байгууллага

1
50

тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 4 зорилт, 9 чиглэлийн хүрээнд дээрх тэгш бус байдлыг бууруулах 13 үйл ажиллагааг төлөвлөн 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. Төлөвлөгөөнд тусгасны дагуу эрэгтэйчүүдэд зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгаа, үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг сумдын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэдийн төв, Насан туршийн нэгж зэрэг байгууллагатай хамтран зохион байгуулснаар нөхөн үржихүйн насны 6000 гаруй эрэгтэй,цэргийн насны 3214 залуучууд нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдаж өвчлөлийн байдал, эмчлэн эрүүлжүүлэх арга зам тодорхойлогдсон. Мөн Ковидын улмаас эмнэлэг, нийгмийн үйлчилгээнд хамрагдах байдал хязгаартай байдал арилж, эрүүл мэнддээ тавих хувь хүний хандлага сайжирсан. Тухайлбал: Ковидоор өвчилсний улмаас биемахбод, сэтгэлзүйд гарсан өөрчлөлтийг эрүүл мэндийн ажилтанд танилцуулж, зөвлөгөө мэдээлэл авч, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамрагдах арга замыг иргэдийн дийлэнх хувь нь мэддэг болсон. Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/625 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндийн салбарт 2021-2024 онд хэрэгжүүлэх "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар

90.0

90.0

ажил, ар гэрийн
амьдралын тэнцвэрийг
хангах чиглэлээр
зөвлөмж гарган
хэрэгжүүлэх

баримтлах бодлого"-ын хэрэгжилтэд Эрүүл мэндийн яамнаас явцын хяналт, үнэлгээ хийгдэж, зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийг байгуулж, хүний нөөцийн хангалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээндээ жендэрийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлан ажиллаж байна. Тухайлбал: Өнөөгийн байдлаар аймгийн эрүүл мэндийн салбарын нийт 1631 ажилтны 1339 буюу 82.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь бодлогын зорилтыг /60:40/ хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Мөн тайлант онд Эрүүл мэндийн сайдын А/240 дүгээр тушаалаар "Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам"-ыг баталсан. Журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өрх толгойлсон эцэг, эх, бага насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй зэрэг ажилтнуудад ажлын цагийг уян хатан нөхцөлөөр зохицуулах, шаардлагатай тохиолдолд гэрээсээ цахимаар ажиллах боломжийг олгон ажилласан.

ЗОРИЛГО 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог хөгжүүлнэ.

Зорилт 3.1. Бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн статистик, жендэрийн дүн шинжилгээний хүртээмж, ашиглалтыг сайжруулна.

3.1.1	Төрийн байгууллагын захиргааны статистик	-	- статистик мэдээ	1	2	Төрийн байгууллагын захиргааны статистик мэдээллийг хүйсээр	90.0	90.0
-------	--	---	-------------------	---	---	---	------	------

мэдээллийг хүйсээр ангилж гаргах, ашиглах, дүн шинжилгээ хийх, үр дүнг хэрэглэгч, олон нийтэд хүргэх

ангилагч гаргаж, байгууллагын хүний нөөцийн менежментэд ашиглаж байна.

Төрийн албан хаагчдын тоо бүртгэл, статистик мэдээллийг албан тушаалын ангилал, зэрэглэл, төрөл тус бүрээр хүйсээр гаргаж, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад ашиглахад дэмжлэг үзүүлэх

- ТАХ-ийн хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ

2024 оны жилийн эцсийн хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаагаар аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын 545 төрийн алба хаагчдын 53,1 хувь нь эмэгтэйчүүд, 46,9 хувь эрэгтэйчүүд, багийн дарга нарын 90,1 хувь нь эрэгтэйчүүд, 9,9 хувь нь эмэгтэйчүүд, улс төрийн албан хаагчдын 10,4 хувь нь эмэгтэйчүүд, 89,6 хувь нь эрэгтэйчүүд, төрийн захиргааны байгуулагуудын албан хаагчдын 53,6 нь эрэгтэй, 46,4 хувь нь эмэгтэйчүүд, төрийн захиргааны удирдах албан тушаалтны 45,0 хувь нь эмэгтэйчүүд, 55,0 хувь нь эрэгтэйчүүд, хэлтэс албадын дарга нарын 40,0 хувь нь эрэгтэйчүүд, 60,0 хувь нь эмэгтэйчүүд, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтны 31,5 хувь нь эрэгтэйчүүд, 68,5 хувь нь эмэгтэйчүүд, төрийн үйлчилгээний албан хаагчдын 44,2 хувь нь эрэгтэйчүүд, 55,8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зорилт 3.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чадавхыг дээшлүүлж, бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тогтолцоог тэгш боломжийн агуулгаар бэхжүүлнэ.

3.2.1 Жендэрийн мэргэжилтэн, сургагч багшийг орон нутагт үе шаттайгаар бэлтгэх

2.5 сая

- сургагч багшийн тоо

-

3

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, багуудын ажлын албаны төлөөлөл 36 албан хаагчид “Жендэр ба хүний эрх” сургалтыг зохион байгуулж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн

90.0

90.0

90.0

70.0

3.2.2	Бүх сумд, аж ахуйн нэгж байгууллагад жэндэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх	- төлөвлөгөө батлуулсан сум, байгууллага	19 сум 30 аж ахуйн нэгж байгууллага	дарамтаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өглөө. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан 16 хоногийн аянд салбар хорооноос орон нутгийн байгууллагууд, сумдыг уриалан, үйл ажиллагааг идэвхжүүлж, амжилттай оролцлоо. Аянд албан ёсоор нэгдэж, жэндэрийн хэвшмэл, ташаа ойлголтоос татгалзах агуулга бүхий нөлөөллийн үйл ажиллагааг эрчимтэй давалгаалж, давхардсан тоогоор 94 байгууллага, 12 аж ахуйн нэгж, 19 сум жил бүр идэвхтэй оролцлоо. Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах, жэндэрийн хэвшмэл ойлголт, жэндэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлж, давхардсан тоогоор 88 байгууллагад 46 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг танхимаар зохион байгуулж, иргэд, албан хаагчид, эцэг эхийн төлөөлөл 2200 орчим хүн хамрагдсан байна. Мөн цахим орчинд байршуулсан нөлөөллийн үйл ажиллагаа 15000 орчим хүнд хүрсэн байна.	70.0	70.0
Зорилт 3.3. Жэндэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх түвшинд нэвтрүүлнэ.						
3.3.1	Төсвийн шууд захирагчдын ЖМТ-ийг хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх сургалтад хамруулах	- сургалтад хамрагдсан удирдлагын тоо	20	"Жэндэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" сургалтад аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нар нийт 8 хүн оролцож, мэдээлэл авлаа.	70.0	70.0
Зорилт 3.4. Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах бүтэц тогтолцоог бэхжүүлж, хамтын ажиллагааг сайжруулна.						
3.4.1	Сумдын дэд хорооны ажлыг эрчимжүүлж, төр,	- дэд хорооны тоо	19 10	Сумдын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд орон нутагтаа	90.0	90.0

хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагад жендэрийн орон тооны бус мэргэжилтэн ажиллуулах

– орон тооны бус мэргэжилтний тоо

жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, сумын дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган, дэд хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 19 сумаас 12 сум дэд зөвлөлийн ажлаа эрчимжүүлээд байна.

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, багуудын ажлын албаны төлөөлөл 36 албан хаагчид “Жендэр ба хүний эрх” сургалтыг зохион байгуулж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өглөө.

Аймгийн Жендэрийн салбар хороо 2024 оны 04 сард хуралдаж, 15 хүн оролцож, жендэрийн салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-г танилцуулж, цаашид хэрэгжүүлэх хамтран ажиллах талаар санал солилцлоо.

3.4.2 Жендэрийн мэргэжилтнүүд харилцан мэдээлэл, солилцох, туршлага судлах, суралцах, чадавх бэхжүүлэхэд дэмжих

- туршлага судлах аялалын тоо

1

70.0

70.0

3.4.3 Жендэрийн асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааны тусгайлсан хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах

500.0 мянга

- хэлэлцүүлэг, уулзалтын тоо

2

90.0

90.0

ЗОРИЛГО 4. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.

Зорилт 4.2. Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангана.

4.2.1 Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтнуудын жендэрийн мэдрэмж, хандлагыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах

- сургалтын тоо

1

2

- сургалтад оролцсон албан хаагчдын тоо

53

100

90.0

90.0

Аймгийн Цагдаагийн газраас Хүний эрхийн комиссын Өвөрхангай аймаг дахь салбар, ХХҮГ, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хандаж, “Жендэр ба хүний эрх”, “Хөгжлийн бэрхшээл ба хандлага, ойлголт” сэдвээр алба хаагчиддаа сургалт авч, цахим болон танхимаар нийт 142 алба хаагч хамрагдсан байна.

Төрийн байгууллагын албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байрны бэлгийн 500.0 мянга	- сургалт авсан байгууллагын тоо	6	10	"Ажлын байр бэлгийн дарамтгүй орчин" сарын аяны хүрээнд "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран Арвайхээр, Хархорин сумын 13 төрийн байгууллагат сургалт зохион байгуулж, 300 орчим ажилтан албан хаагч хамрагдлаа.	90.0	90.0
дарамтаас урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	- сургалтад оролцсон албан хаагчдын тоо	164	250			

Зорилт 4.3. Нутгийн өөрөө удирдах болон аж ахуйн нэгж, байгууллагын шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангана.

Иргэний нийгмийн байгууллагын удирдах түвшний эмэгтэйчүүдэд жендэрийн эрх тэгш 300.0 мянга	-сургалтад хамрагдсан ТББ-ын тоо	-	5	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 5 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, байгууллагын удирдлага эмэгтэйчүүдэд "Эмэгтэйчүүдийн манлайлал" сургалтыг зохион байгуулж 14 хүн хамрагдлаа.	90.0	90.0
байдлыг хангах сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	-хамрагдсан удирдлагын тоо	-	6			

ЗОРИЛГО 5. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана.

Зорилт 5.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох /харгалзан зохицуулах бодлого, түүний удирдлагыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлнэ.

Гамшгийн эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг даван туулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх салбар дундын төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлал тусгах	-хэрэгжилтийн хувь	-	80-аас дээш хувь	Аймгийн Онцгой байдлын газраас ангиллын сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хийж гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 1 удаа 829, гамшгаас хамгаалах команд штабын сургууль 3 удаа 303, удирдах бүрэлдэхүүний сургалт 10 удаа 217, ажилтан албан хаагчийн сургалт 50 удаа 1009, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт 12 удаа 500, иргэдийн сургалтыг 13 удаа 1738, цэргийн дүйцүүлэх албаны сургалт 4 удаа 140, сайн дурын бүлэг хэсгийн сургалтыг 2 удаа 166, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт 1 удаа 43, Политехник коллежийн багш,	90.0	90.0
---	--------------------	---	------------------	--	------	------

Зорилт 5.2. Байгаль орчныг хамгаалах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэхэд жендэрийн тэгш оролцоог хангана.

сурагчдад 2 удаа 484, ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад 11 удаа 1405, дунд ангийн сурагчдад 19 удаа 2761, бага ангийн сурагчдад 12 удаа 756, сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтыг 11 удаа 375 хүүхдэд нийт 152 удаагийн сургалтаар 10726 хүнд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулан ажилласан байна.

Орон нутгийн хүнсний үйлдвэр эрхлэгчдийн бүтээмжийг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь туслах зорилгоор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран аймгийн хүнс үйлдвэрлэгчдийн "Амталгаат өдөрлөг"-ийг Сансар, Номин худалдааны төвүүдэд зохион байгуулж, сурталчилгаа хийсэн.

5.2.1 Эрүүл, ногоон хүнс үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулах, хэрэглээний зөв дадлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөж хэрэгжүүлэх

-хэрэгжилтийн хувь

80-аас дээш хувь

"Хөгжлийн шийдэл" ТББ-ын Бест хөтөлбөртэй хамтран сумдын махны үйлдвэр, мал төхөөрөх цэг, махны анхан шатны боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, иргэдэд "Мах боловсруулах үйлдвэрийн чанарын удирдлагын тогтолцос, зохистой дадлын сургалт"-ыг зохион байгуулж, 8 сум, 12 аж ахуйн нэгжийн албан хаагчид оролцсон байна. Бүх сумдын иргэд, хэрэглэгчдэд хоол, хүнсний зохистой хэрэглээний зөв дадлыг төлөвшүүлэх зорилгоор цахимаар 10 цуврал контентийг түгээж, танхимаар

90.0

90.0

<p>5.2.2 Жендэрийн тэгш оролцоог хангасан ногоон ажлын байрыг бий болгох хүрээнд сайн туршлагыг орон нутагт түгээн сурталчлах</p>	-	<p>-оролцсон байгууллага, сумын тоо</p>	-	<p>10 байгууллага 13 сум</p>	<p>27 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж, 8358 хүнийг хамруулсан байна.</p> <p>Хүүхэд, залуучуудад байгаль орчныг хайрлан хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгох, байгаль орчинтой зөв харьцах дадал хэвшүүлэх зорилгоор 26 сургуульд эко клубыг ажиллуулж, тэднээр дамжуулан нөлөөллийн ажлууд зохион байгуулж байна. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд "Ан амьтад" гэрэл зургийн үзэсгэлэн, Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд арга хэмжээг зохион байгуулж, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан сурталчилж байна.</p>	90.0	90.0
<p>Зорилт 5.3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чадавхыг эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд бүрдүүлнэ.</p>							
<p>5.3.1 Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх</p>	-	<p>-сургалт нөлөөллийн ажлын тоо - оролцогч эмэгтэйчүүдийн тоо</p>	-	<p>3 15</p>	<p>Орхоны хөндийн аяллын гол үзмэр Эртний нийслэл Хархорум хотын түүхийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэмжлэгтэйгээр "Торгоны зам-Хархорум хот" эрдэм шинжилгээний цахим хурлын илтгэлүүдээр товхимол бэлтгэж, 500 ширхэг хэвлүүлж түгээгээд байна.</p>	90.0	90.0

5.3.2 Цөлжилтийг сааруулах үйл ажиллагаанд оролцож буй орон нутгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах

1.5 сая

-бүлэг нөхөрлөлийн тоо

-

Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, аяллын батлагдсан маршрутууд бүхий Uvurkhangaitravel гар утасны аппликейшныг иргэд, олон нийтэд цахим сүлжээгээр сурталчилж ажилласан. Хужирт сумын 5 дугаар багт "Хужирт Цагаан" ХХК сүүн чихрийн үйлдвэр нээж, бүтээгдэхүүнээ орон нутагтаа үйлдвэрлэж байна. Үхэр, хонь, ямааны сүүг малчдын гар дээрээс худалдан авч, боловсруулан, сүүн чихэр, бурамтай, зөгийн балтай, хушгатай, чацарганатай сүүн чихэр, резинэн чихэр зэрэг чихрүүд үйлдвэрлэж, өөрийн аймаг төдийгүй улсын хэмжээнд худалдан борлуулж, брэнд бүтээгдэхүүн болсон байна.

Ой цэвэрлэгээгээр мод бэлтгэх ажилд 11 аж ахуйн нэгж, 12 нөхөрлөл оролцож, ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд 10 га талбайд ойжуулалт хийж, 3800 га талбайд ойн хортон хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажил хийсэн байна. Бат-Өлзий сумын ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 9,000 ширхэг модыг тарьсан бөгөөд шинэсний тарьцаар гүйцэтгэх ойжуулалтын ажлыг 10 га талбайд хийсэн байна. Улсын төсвөөр гүйцэтгэх "Газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Баруунбаян-

90.0

90.0

				Улаан суманд 8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэжээ.	
Дундаж үнэлгээ					87.1 хувь 84.2 хувь



ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ХЯНАЖ, ЗӨВШӨӨРСӨН:
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *[Signature]* М.БАТЗОРИГ

ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 ДАРГА *[Signature]* Т.ҮРЖИНПҮРЭВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОЛЛОГЫН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Э.ХОРОЛСҮРЭН